

**Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал** (2014 оны 8 дугаар сарын байдлаар)

**I. Нийгмийн үзүүлэлт**



**I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.**

2014 оны 8 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1043 болж, 2013 оны мөн үеэс 462 хүнээр өсч, өмнөх сарынхаас 7 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 48,90 хувь буюу 510 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 1465 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 1006 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 39,26 хувь буюу 395 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 8 дугаар сарын эцсийн байдлаар**




Тайлант сард бүртгүүлсэн 549 ажилгүй иргэний 42,3 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 11,3 хувь нь нэмэдлэг чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 10,3 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 10,1 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 8,7 хувь нь өөр газраас шилжин ирсэн; 5,5 хувь нь орон тооны цомхтголд

орсон; 2,2 хувь нь байгууллага татан буугдсан; 1,7 хувь нь гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1,1 хувь нь цэргээс халагдсан; 0,6 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих; 0,2 хувь нь тэтгэвэрт гарсан; 0,2 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 5,9 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 5,56% нь дээд; 16,78% нь тусгай дунд; 48,32% нь мэргэжлийн анхан шатны; 8,72% нь бүрэн дунд; 4,79% нь бүрэн бус дунд боловсролтой; 15,82% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар**



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



**I.2 Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 8 сард НДШ-ийн орлого 7.59 тэрбум ₮ болж төлөвлөгөө 70.68 хувь боллоо, төлөвлөгөөг бүх сум 14.80 – 33.79 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 405.2 сая ₮ болж төлөвлөгөө 82.53 хувь болж, бүх сум 1.53-34.12 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 20.5 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.0 хувийг өндөр настны, 11.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 227700 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 37.90% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 28.29%; тэтгэмжийн даатгалын сангийн 104.26%; эрүүл мэндийн даатгалын сангийн 80.06%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 204,91 %; ажилгүйдлийн даатгалын сангийн 156,41 %-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 8 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 48241 хүнд олгож, 7.1 тэрбум ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 6.12 хувь 3149 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 42.66 хувь 2.1 тэрбум ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 104470 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 33.68 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 25.67 хувийг халамжийн тэтгэвэр; 10.02 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.25 хувийг төрөл бүрийн нөхцөлт

мөнгөн тусламж; 2.22 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.89 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.98 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




### 1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 8 сард 10651 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.9 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 8 сард 919 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 117 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 8 н сард нялхсын эндэгдэл 5 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 3-аар буурсан байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд 1 хүүхэд гарсан ба өмнөх онд 1 хүүхэд буюу ижил байна.

Зураг 1.4


**Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар**



2014 оны эхний 8сард нийт гарсан халдварт өвчнөөр 330 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 29.4 хувь буюу 138 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.5 дахин, заг хүйтэн 1.4 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 37байгаа бол: Зуунмод 104, Сүмбэр 76, Мөнгөнморьт 61, Сэргэлэн 38, Дэлгэрхаан 32, Цээл 32 ногдлоо..

Зураг 1.5

**10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар**



**1.4 Байгаль орчин**

**Цаг агаарын тойм, агаарын бохирдол**

- агаарын дундаж температур 13-19 градус дулаан буюу Өндөрширээт

орчмоор дулаан, Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 25-32 градус буюу Бүрэн, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн, Жаргалант, Угтаал, Заамар, Борнуур, Залуучууд орчмоор 32-33 градус хүрч халсан байхад нутгийн зүүн хойд хэсэг болох Мөнгөнморьт, Эрдэнэ орчмоор 25-26 градус дулаан байв.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 2,0 градус хүйтнээс 6,0 градус дулаан буюу Заамар, Өндөрширээт орчмоор 5-6 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр сэрүүвтэр Эрдэнэ орчмоор 2 градус хүйтэн ажиглагдсан байв.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 5,0-40,1 мм, нутгийн баруун өмнөд хэсгээр бага үүнээс Өндөрширээтэд 5,0 мм хамгийн бага нь, нутгийн зүүн хойд хэсэг болон зарим газраар арай ахиу, үүнээс хамгийн их нь Жаргалант, Баянчандмань, Мөнгөнморьт, Эрдэнэд 31,6-40,1 мм бороо оржээ.

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар 9-14 градус дулаан буюу хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад ихэнх нутгаар олон жилийн дунджаас 0,5-1,0 градусаар дулаан байх төлөвтэй.

Хүйтрэх хугацаа: Хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн

цочир хүйтэрнэ, өдөртөө 8-13 градус дулаан байна.

Сэрүүсэх хугацаа: Нэгдүгээр арав хоногийн дунд үе болон эцсээр уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 7-12 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5 градус дулаан, хөрсний гадаргад 0-5 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 12-17 градус дулаан байна

Харьцангуй дулаарах үе: Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 0-5, өдөртөө 15-20 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 7-12, өдөртөө 22-27 градус дулаан.




### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 8 сард аймгийн хэмжээнд 642 гэмт хэрэг бүртгэгдэж 499 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1.84 тэрбум₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 8 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 40.65 хувь нь хулгай, 23.83 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.8 хувь нь бусад хэрэг. 16.20 хувь нь замын осол, 3.12 хувь нь танхай дээрэм, 1.40 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Аргалант, Эрдэнэ, Баян, сумдад 10000 хүнд 300-110 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (73)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, тэр-бум төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 26 хэргээр өслөө.


Зуунмод суманд 31 эмэгтэй, 764 эрэгтэй нийт 795 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 33 хүнээр өслөө.



### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 8 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 1261

гүйцэтгэх хуудсанд нийт 3.50 тэрбум₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 489 гүйцэтгэх хуудсанд ногдох 618.4 сая₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 772 гүйцэтгэх хуудасны 2,88 тэрбум₮-өөс 360 хуудасны 1,57 тэрбум₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 46.63 хувь, үнийн дүнгээр 54.61 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 11.45 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 25.24 нэгжээр тус тус өслөө.



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 8 сард кассын орлого 455.3 тэрбум ₮, кассын зарлага 455.0 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.3 тэрбум ₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад **жижиг худалдаа, үйлдвэрлэлийг** дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 8 сарын 31-ний байдлаар **117.3** тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс **26.3** тэрбум ₮-өөр өслөө. 2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд

зээлдэгч нарт **92.9** тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 8 сарын 31-ний байдлаар 42.4 тэрбум ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 8 сарын 31-ны байдлаар 284351 иргэний 9.1 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.19-1.34 хувь, хугацаатай доод хүү 0.62-0.65 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0.60-0.62 хувьтай байна.



### II.2 Төсөв, мөнгө

Орон нутгийн төсвийн орлого 7.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 131.25 хувиар биелэлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.3 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 253.71 хувь биелж, Алтанбулаг сум 13.47 хувиар тасалдууллаа.



Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 6.0 тэрбум ₮ болж 115.01 хувь биелж, Баянжаргалан, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Цээл, Баянхангай, Өндөрширээт, Мөнгөнморьт, Эрдэнэсант, Угтаал, Батсүмбэр, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Бүрэн сумд 38.84-0.98 хувиар тасалдууллаа




### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 8 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үеболох 2010 оны 12 дугаар сараас 46,70%, өмнөх оны мөн үеэс 12.71%-аар тус тус өсч, өмнөх сараас 0,01 хувиар буурав.

8 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 31,2%; мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 11,7%; сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 2.25%; жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 1.9%-аар тус тус буурсан нь ерөнхий индекс өмнөх сараас 0,01 хувиар буурахад нөлөөлөв. Харин талх гурил, будааны дэд бүлгийн үнэ 6,52%; саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ 1,71%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,95%; төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ 0,48%; согтууруулах бус ундаа 0.32%-аар тус тус өсөв.

Зураг II.4

#### Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 8 дугаар сарын 0.01 хувийн бууралтынгол шалтгаан нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнийн бууралт байлаа.

Зураг II. 5

#### Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл


Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 8-р сард пунктээр
<b>Бүгд</b>	<b>-0.01</b>
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	-1.02
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.04
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.34
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.05
05. ГЭР АХҮЙН ТАВИЛГА, ГЭР АХҮЙН БАРАА	0.05
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.07
07. ТЭЭВЭР	0.00
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.07
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.25
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.01
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.14



#### Хөдөө аж ахуй

Ургац хураалтын мэдээллээр аймгийн хэмжээнд 09 сарын 01-ний байдлаар үр тариа 2008.8 тонн, төмс 5152.5 тонн, хүнсний ногоо 292.8 тонн хурааж, бэлтгэсэн өвс 24519.7 тонн, гар тэжээл 163.4 тонн бэлтгэв. Урьд оны мөн үеэс үр тариа 2008.8, төмс 3793.5 тонн, хүнсний ногоо 124.1 тонноор өслөө.

Ургац хураалт, өвс хадлан, гар тэжээл бэлтгэлт, 9 дүгээр сарын 1-ний байдлаар







## II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 8 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 10.17 тэрбум₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 1.38 дахин буюу 5.19 тэрбум₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Баянчандмань, Баянцагаан, Зуунмод, Жаргалант, Баянцогт, Алтанбулаг, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Өндөрширээт, Заамар сумд 31.36-0.49 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 95.65) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мянган төгрөг  
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 VIII	2014 VIII	2013 I-VIII	2014 I-VIII	Дүнд эзлэх % Percentage share to total	
					2013-I-VIII	2014-I-VIII
Нийт дүн	543.60	2,257.33	4,257.71	10,172.92	100.0	100.0
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	165.77	1,214.85	674.71	5,143.22	15.85%	50.72%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	376.84	1,042.06	2,310.67	4,040.21	54.27%	39.72%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	0.99	0.42	1,272.33	989.49	29.9	97.3

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ундаа үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 17 дахинаас -26.2 хувь буюу 4.46 тэрбум-3.6 сая₮-өөр өссөн нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 8 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 9.73, боловсруулах үйлдвэрлэл 39.72, уул уурхайн үйлдвэрлэл 50.65 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, хувиар



## II.6 Барилга


Төвийн аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 8 сард 3247.4 сая₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 39.76 хувь буюу 923.8 сая₮-өөр өсөв. Барилга угсралт их засварын ажлын 19.94 хувь нь орон сууцны барилгад; 54.56 хувь нь орон сууцны бус барилгад; 22.50 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Энэ нь 2013 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилгын ажил 15,57 пунктээр өсч, орон сууцны бус барилгын ажил 5,73 пунктээр; инженерийн барилга

байгууламжийн ажил 20,59 пунктээр тус тус буурсан үзүүлэлт юм.

Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 48 хүнээр буурч, цалингийн сан 184,1 сая₮-өөр өсөв.

Зураг II.8

**Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр**



**II.7 Холбоо**

Холбоо ашиглалтын орлого оны эхний 8 сард 178.8 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 93.4 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 11.9 хувь буюу 19.0 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 64.8 сая ₮ болж, нийт орлогын 80.6 хувь нь хүн амд үйлчилсэний орлого бүрдүүллээ. Нийт орлогын 19.39 хувийг албан бичгийн, 12.81 хувийг зорчигчдийн, 67.8 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

**Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр**

